

2020 он 02 сар 18 өдөр

Дугаар 20/03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 76 дугаар зүйлийн 76.1.12, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 сарын 18-ний өдрийн эчнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 12.65% (арван хоёр зууны жаран таван хувь)-иар буюу 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 34.95 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 4 сарын 7-ний өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-иар зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2020 оны 4 дүгээр сарын 30-ны дотор олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлэлцээр байгуулж гэрээнд гарын үсэг зурахыг Гүйцэтгэх Захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.БАТБАЯР